



ЖАНЛАВЫН НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч
1996-1998 он

Улаанбаатар хотод 1957 оны 6 дугаар сарын 10-нд төрсөн. Дундговь аймгийн 10 жилийн дунд сургууль, 1981 онд ЗХУ-ын Москва хотын Газар зохион байгуулалтын Их сургууль, 1987 онд МУИС-ийг тус тус төгссөн. Газар зохион байгуулагч-инженер мэргэжилтэй. Улс төрийн дээд боловсролтой. Газар зүйн ухааны доктор (PhD), Москвагийн Газар зохион байгуулалтын Их сургуулийн хүндэт профессор, МУИС-ийн зөвлөх профессор цолтой.

1981-1989 онд ХААЯ-ны Газар зохион байгуулалтын институтэд инженер, ахлах инженер, ерөнхий мэргэжилтэн, 1989-1991 онд БОЯ-ны Газрын бодлогын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, секторын эрхлэгч, 1991-1996 онд Улаанбаатар хотын АДХГЗ-ны Хот байгуулалт, төлөвлөлтийн газар хэлтэс, албаны дарга, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ахлах мэргэжилтэн, 1996 онд Нийслэлийн

газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн албаны дарга,

1996-1998 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 1998-1999 онд Монгол улсын Ерөнхий сайд, 1999-2000 онд МУИС-д багшийн албыг тус тус хашиж байсан. 2000-2004 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажилласан.

2007 оны 11 сарын 12-ны өдөр Дундговь аймагт болсон хуралд оролцоод буцаж явах замдаа автомашины ослоор нас барсан.